

## “Ногоон хөгжил” хөтөлбөрийн хүрээнд хийж буй ажил

“Ногоон хөгжил” хөтөлбөрт байгаль орчны чиглэлээр 5 зорилтын 46 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй ажлуудаас дурьдвал:

- Аймгийн Байгаль хамгаалах сангийн Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 2013 онд 5.7 тэрбум төгрөг, 2014 онд 5,4 тэрбум төгрөг, 2015 онд 5,3 тэрбум төгрөгийг хуваарилан ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж, байгалийн унаган төрхийг хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглахад чиглэхэд зарцуулж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлыг 1019 га-д, ногоон хэрэм, цөлжилтөөс хамгаалах ажлыг 87 га-д хийж, хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлыг өмнөх оноос 3,5 дахин нэмэгдүүллээ.

Байгаль хамгаалах сангаас 12 суманд тус бүр 10,0 сая төгрөг, 5 суманд тус бүр 20,0 сая төгрөгийг ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор олгож, сум бүр 0,5-1 га талбайг шинээр хашаажуулж, мод тарьж ургуулан ногоон байгууламжийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлээд байна.

Мод тарих үндэсний өдрийн хүрээнд “Тарьц суулгацын үзэсгэлэн худалдаа”-г зохион байгуулж, аймгийн хэмжээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлж, төв суурин газруудын **303487** м<sup>2</sup> талбайд 334334 ширхэг мод бут тарьсан нь өмнөх оноос 25 хувиар нэмэгдлээ.

Мөн ойн хортон шавжийн тэмцлийн ажлыг 60000 га талбайд, судалгааны ажлыг 354000 га талбайд хийж гүйцэтгэсэн нь сүүлийн 5 жилийн дунджаас 30 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Ойн нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлж ойн санд тархсан хортон шавжийг устгуулах зорилгоор Орхон, Бугат, Сэлэнгэ, Хангал сумдын 12 нөхөрлөлд хүлэмж, услагааны систем, бордоо, модны үр, багажаар хангаж, 249 ш гэрлэн урхийг 80–иад нөхөрлөлд олгоод байна.

Бүрэгхангай, Баяннуур, Гурванбулаг, Дашинчилэн, Орхон, Могод, Рашаант, Сайхан, Хишиг-Өндөр, Баян-Агт сумдын бэлчээрийн 57,0 мянган га талбайд байгальд сөрөг нөлөөгүй аргаар хортон мэрэгчидтэй тэмцэх арга хэмжээг орон нутгийн малчдын бүлгийн оролцоотойгоор зохион байгуулан ажиллаж байна.

Цөлжилтийн болон бэлчээрийн нарийвчилсан судалгааг 16 сумын нутагт хийж гүйцэтгүүлснээр бэлчээрийг зохистой ашиглах, цөлжилтөөс урьдчилсан сэргийлэх арга хэмжээг авах ач холбогдолтой юм.

Хог хаягдлыг бууруулах, орчны бохирдлыг багасгах ажлыг зохион байгуулж Булган аймгийн төв Булган сумын төвлөрсөн хогийн цэгт хог хаягдлыг ландшафлын аргаар дарж булах ажлыг хэрэгжүүлж, 15 сум, 1 тосгонд ухдаг, түрдэг трактор, хатуу хог хаягдлыг тээвэрлэх 17 ш кама маркын өөрөө буулгагч автомашин, 1 ш хог шахаж нягтруулагч автомашиныг сумдад хүлээлгэн өглөө.

Булган сумын нийтийн эзэмшлийн талбай, айл өрхөд хог төрөлжүүлэн хийх хогийн сав нийлүүлэн Булган сумын орон сууцны гадаа 22ш, нийтийн эзэмшлийн талбайд 80ш болон 1-р багийн 218 айл өрхөд хогийн савыг байрлууллаа.

Мөн төвлөрсөн хогийн цэгийн дэргэд байгуулсан хог ангилан ялгах цехэд 82.2 сая төгрөгөөр цахилгааны шугам татах, 99.1 сая төгрөгөөр хог ангилан ялгах тоног төхөөрөмж нийлүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Булган сумын айл өрхөд түлшний хэмнэлттэй утаа бага гаргадаг 800 зуух нийлүүлсний дээр энэ онд 300 зуухыг нэмж нийлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Дашинчилэн, Орхон сумдын нутаг дэвсгэрт иргэдийн гар аргаар алт олборлон эвдэрсэн 13,6 га газрыг нөхөн сэргээлээ.

Улсын төсвийн 68,4 сая төгрөгийн хөрөнгөөр Могод сумын Бумбатын голд хөв цөөрөм байгуулан ашиглалтад оруулж, бэлчээрийг зохистой хуваарилан ашиглах боломж бий болгож, цөлжилтийг сааруулах нөхцөл бүрдлээ.

Аймгийн хэмжээнд 98 булгийн эхийг хашиж хамгаалж, 10 сумын 14 худагт ус цэнгэгжүүлэх, зөөлрүүлэх тоног төхөөрөмж суурилуулах ажлыг хэрэгжүүлээд байна.